14

# ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
# ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
# САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 05 сарын 15 өдөр Дугаар 06 Арвайхээр

Шалгалтын комисс байгуулах тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам"-ын 1.3.2, 3.1, 3.2, 7.1 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 3.5.1, 3.5.3 дахь заалт, Төрийн албаны тусгай шалгалт зохион байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай" Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 141 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн захиргааны удирдах, гүйцэтгэх албан тушаал (Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга, Уянга сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга, Баян-Өндөр, Өлзийт, Хужирт сумдын Засаг даргын даргын Тамгын газрын дарга, Уянга сумын Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн албаны дарга, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Барилга, хот төлөвлөлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэр, хөтөлбөр, сургалт мэдээлэл хариуцсан мэргэжилтэн, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Төгрөг, Бат-Өлзий, Бүрд, Есөнзүйл сумдын Газрын даамал, Орон нутгийн өмчийн газрын Ажил худалдан авалт хариуцсан мэргэжилтэн, Хүнс, хөдөө аж ахуйн газрын Үйлдвэр, худалдаа, үйлчилгээний албаны Худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн, Малын генетик нөөцийн ашиглалт, эрчимжүүлэлт, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Эрүүл мэндийн газрын Эрүүл мэндийн боловсрол, мэдээлэл, сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн)-ын төрийн албаны тусгай шалгалт зохион байгуулах шалгалтын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | |
|---|---|
| Салбар комиссын дарга: | Ц.Ганболд -Салбар зөвлөлийн дарга |
| Гишүүд: | Н.Энхцэцэг -Салбар зөвлөлийн гишүүн |
| | Б.Сайнжаргал -Салбар зөвлөлийн гишүүн |
| | Н.Чимэддорж-Ойдов -Салбар зөвлөлийн гишүүн |
| Нарийн бичгийн дарга: | Э.Бадамгэрэл -Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга |

2. Шалгалт зохион байгуулах бэлтгэлийг хангаж ажиллахыг Шалгалтын комиссын нарийн бичгийн дарга (Э.Бадамгэрэл)-д даалгасугай.

3. Төрийн албаны тусгай шалгалтыг холбогдох журам, Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 141 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх аргачлал, Төв комиссоос өгсөн үүрэг чиглэлийн дагуу зохион байгуулж, шалгалтын тайлан, холбогдох материалыг хугацаанд нь хүргүүлэхийг Шалгалтын комисст үүрэг болгосугай.

ДАРГА Ц.ГАНБОЛД

УХА0115
13

13100001

# ТӨРИЙН АЛБАНЫ ТУСГАЙ ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН ТАЙЛАН

2020.05.19

**Төрийн албаны тусгай шалгалтын зарыг нийтэд зарлах, мэдээлэх талаар:**

Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын сул орон тоо (Баян-Өндөр сумын ЗДТГ-ын дарга, Хужирт сумын ЗДТГ-ын дарга, Өлзийт сумын ЗДТГ-ын дарга, Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга, Уянга сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга, Уянга сумын ЗДТГ-ын Санхүүгийн албаны дарга)-ны зарыг Төрийн албаны зөвлөлийн csc.gov.mn цахим хуудсанд байршуулснаар uvurkhangai.mn цахим хуудас, нийгмийн сошиал хуудас болон орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, Төрийн үйлчилгээний нэгдсэн төв, Иргэдэд мэдээллээр үйлчлэх төв, байгууллагын мэдээллийн ил тод байдлын самбар, сумдын ЗДТГ-аар дамжуулан зар, мэдээллийг иргэдэд ил тод нээлттэй хүргэлээ.




Төрийн албаны тусгай шалгалтад цахимаар бүртгүүлэх, шалгалтад орох иргэдэд зар, зөвлөмж, мэдээллийг хүргэх зорилгоор санамж, анхааруулга бэлтгэн нийгмийн сошиал хаяг, аймгийн албан ёсны вэб сайтад байршуулан, иргэдэд тараах материал байдлаар хүргэж, Салбар зөвлөлийн 7032-3538 утсанд хандсан иргэдэд сул орон тооны зар, төрийн албаны тусгай шалгалтын цахим бүртгэл, шалгалтын тухай мэдээллийг дэлгэрэнгүй хүргэж ажилласан.












**Төрийн албаны тусгай шалгалтын цахим бүртгэлийн талаар:**

2020 оны 05 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулах тусгай шалгалтад орох иргэдийн баримт бичгийг 2020 оны 05 дугаар сарын 14-нд 09.00-17.00 цагийн хооронд цахимаар хүлээн авахад нийт 8 иргэн баримт бичгээ ирүүлсэн. Мөн тухайн өдөр 3 иргэн шалгалтад бүртгүүлэхээр цахимаар баримт бичгээ илгээсэн гэсэн боловч цахим бүртгэлээр ирээгүй байсан тул 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдөр Үндэсний дата төвд хандаж дээрх иргэдээс холбогдох баримт бичгийг цахим бүртгэлийн хаягруу илгээсэн эсэхийг шалгуулахаар хүсэлт хүргүүлснээр Үндэсний дата төвөөс шалгаж дээрх иргэдийн мэйл хаягнаас цахим бүртгэл хийсэн хаягруу ямар нэгэн мэйл ирээгүй байна гэсэн хариуг өгсөн тул иргэдэд утсаар холбогдож мэдээллийг хүргэлээ.

Цахим бүртгэлээр материалаа ирүүлсэн 8 иргэний баримт бичгийн бүрдлийг нягтлан шалгаж, бүртгэлийн дэлгэрэнгүй танилцуулга бэлтгэн шалгалтын комиссын гишүүдэд хүргүүлж, санал авснаар Баян-Өндөр сумын ЗДТГ-ын даргын албан тушаалын шалгалтад орохоор бүртгүүлсэн Д.Сонинбаяр, Хужирт сумын ЗДТГ-ын даргын албан тушаалын шалгалтад орохоор бүртгүүлсэн З.Цэцэгмаа, Б.Янжиндулам, Өлзийт сумын ЗДТГ-ын даргын албан тушаалын шалгалтад орохоор бүртгүүлсэн Л.Гантулга, Санхүүгийн хяналт, аудитын албаны даргын шалгалтад орохоор бүртгүүлсэн М.Эрдэнэчулуун нарыг албан тушаалд тавигдах шаардлагыг хангаж, бичиг баримтаа бүрэн гүйцэд бүрдүүлсэн гэж үзэж шалгалтад бүртгэхээр олонхийн саналаар шийдвэрлэсэн.

Уянга сумын ИТХ-ын нарийн бичгийн даргын албан тушаалын шалгалтад бүртгүүлэхээр цахимаар бичиг баримтаа ирүүлсэн иргэн П.Баатар, Хужирт сумын ЗДТГ-ын даргын албан тушаалын шалгалтад бүртгүүлэхээр цахимаар бичиг баримтаа ирүүлсэн иргэн Д.Мөнхбат, Ц.Галбадрах нарыг дараах үндэслэлээр бүртгэх боломжгүй гэж комиссын гишүүд шийдвэрлэсэн. Үүнд:

Уянга сумын ИТХ-ын нарийн бичгийн даргын албан тушаалын шалгалтад бүртгүүлэхээр цахимаар бичиг баримтаа ирүүлсэн иргэн П.Баатарыг дараах үндэслэлээр бүртгэх боломжгүй гэж шийдвэрлэсэн.

1. Иргэн П.Баатарын гэрт нь 2011 онд гал түймэр гарсны улмаас тухайн иргэний Цэргийн нэгдсэн дээд сургууль төгссөн диплом, Удирдлагын хөгжлийн институт төгссөн диплом, хөдөлмөрийн дэвтэр, нийгмийн даатгалын дэвтэр

шатсан тухай ОБЕГ-ын 2011 оны 0120/01 тоот гамшгаас хамгаалах улсын байцаагчийн гал түймэр гарсан тухай акт, ЦНДС-ийг улс төрийн ажилтан мэргэжлээр төгссөн дипломын хуулбар (эх хувь шатсан), Удирдлагын хөгжлийн институтыг 1995-1997 онд Төрийн удирдлагын арга зүйч, зохион байгуулалт мэргэжил, менжер цол олгосон диломын хуулбар (эх хувь шатсан)-ийг ирүүлсэн. Иймд цаашид диплом эх хувиар байхгүй, ЦНДС-ийг төгссөн улс төрийн ажилтан мэргэжил нь тухайн албан тушаалын тодорхойлолтын мэргэжилд нийцэхгүй, Удирдлагын хөгжлийн институтыг Төрийн удирдлагын арга зүйч, зохион байгуулалт мэргэжил, менежер цол олгосон дипломтой төгссөн боловч диплом шатсантай холбогдуулан 2017 онд УА-ийн Төрийн алба удирдлагын сургуулиас олгосон тодорхойлолт нь төрийн удирдлагын менежерээр төггсөн гэж үзсэн тул төрийн удирдлага гэсэн мэргэжил гэж үзэх боломжгүй.

2. П.Баатар нь төрийн албанд 26 жил ажилласан. 1992.10.10-аас 1996.10.30-ыг хүртэл Уянга сумын ИТХ-ын нарийн бичгийн даргаар, 1996-2000 онд Уянга сумын ЗДТГ-ын Төрийн захиргааны түшмэлээр ажилласан нь төрийн захиргааны дэс түшмэлийн албан тушаалд 4 жил, туслах түшмэлийн албан тушаалд 4 жил ажилласан байна. 2000 оноос хойш сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн дарга, сумын Засаг даргын орлогч, сумын Засаг дарга зэрэг улс төрийн албан тушаал хашиж байгаад 2016 онд чөлөөлөгдсөн. Иймд Төрийн албаны тухай хуулийн 16.3, 46.1, ТАЗ-ийн 2019 оны 17 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх журам”-ын 2.1-т заасан нөөцийн сангийн бүрэлдэхүүн хэсэгт заасан нөөцөд байхгүй тул шалгалтад бүртгэх боломжгүй.

3. Төрийн жинхэнэ албаны Тангараг өргөсөн “Тангарагийн хуудас” хуулбар ирүүлээгүй байна.

Хужирт сумын ЗДТГ-ын даргын албан тушаалын шалгалтад бүртгүүлэхээр цахимаар бичиг баримтаа ирүүлсэн иргэн Д.Мөнхбатыг дараах үндэслэлээр бүртгэх боломжгүй гэж шийдвэрлэсэн. Үүнд:

1. Газар зохион байгуулагч-инженер мэргэжил нь тухайн албан тушаалын тодорхойлолтын мэргэжилд нийцээгүй тул,

2. Төрийн албанд 13.2 жил ажилласан. Үүнээс туслах түшмэлийн албан тушаалд 11.9 жил ажилласан. Тухайн албан тушаалын тодорхойлолтын туршлагын дэс түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байна гэсэн туршлагын шаардлага хангахгүй тул,

3. Үйл ажиллагааны үр дүн мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэсэн илтгэх хуудас (1жилийн) ирүүлсэн боловч хэдэн оны илтгэх хуудас нь тодорхойгүй, баталгаажуулж гарын үсэг зураагүй, дутуу ирүүлсэн тул,

4. Зураг ирүүлээгүй.

Хужирт сумын ЗДТГ-ын даргын албан тушаалын шалгалтад бүртгүүлэхээр цахимаар бичиг баримтаа ирүүлсэн иргэн Ц.Галбадрах дараах үндэслэлээр бүртгэх боломжгүй гэж шийдвэрлэсэн. Үүнд:

1. Төрийн албан хаагчийн анкетыг дутуу бөглөж ирүүлсэн тул,

2. Нийгмийн даатгалын дэвтэр ирүүлээгүй, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн тодорхойлолт ирүүлсэн тул төрийн албанд болон дэс түшмэлийн албан тушаалд ажилласан жилийг тогтоох боломжгүй тул,

3. НДХ-ийн Хужирт сумын Нийгмийн даатгалын байцаагчаар ажилладаг боловч сүүлийн 3 жилийн үйл ажиллагааны үр дүн мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэсэн илтгэх хуудас ирүүлээгүй баримт бичгүүдийг дутуу ирүүлсэн байна.

Уянга сумын ЗДТГ-ын Санхүүгийн албаны даргын сул орон тоонд төрийн албаны тусгай шалгалтад орохоор хүн бүртгүүлээгүй.

Албан тушаалд тавигдах шаардлагыг хангаж, бичиг баримтаа бүрэн гүйцэд бүрдүүлсэн тул шалгалтад бүртгэхээр шийдвэрлэсэн Д.Сонинбаяр, З.Цэцэгмаа, Б.Янжиндулам, Л.Гантулга, М.Эрдэнэчулуун нарт 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдөр утсаар холбогдож шалгалтад бүртгэсэн тухай болон төрийн албаны тусгай шалгалт зохион байгуулах өдөр, цаг, шалгалт авах байршил, иргэний зүгээс хорио цээрийн дэглэмийг чанд сахиж маск, улавч, малгай өмсөж шалгалтад орохыг мэдэгдэж анхааруулав.

**Төрийн албаны тусгай шалгалт зохион байгуулсан талаар:**

Улсын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдал зарлаж, хорио цээрийн дэглэм тогтоосонтой холбогдуулан тусгай шалгалтыг зохион байгуулах хүрээнд Төрийн албаны зөвлөлөөс гаргасан тогтоол, аргачлалын дагуу шалгалтын бэлтгэлийг хангаж, шалгалтыг хэсэгчилсэн байдлаар авах шалгалтын хуваарийг хийж Төрийн албаны зөвлөлийн сонгон шалгаруулалтын газарт хүргүүлсэн.

Төрийн албаны тусгай шалгалт зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд шалгалт зохион байгуулахад шаардлагатай тоног төхөөрөмжийн бэлэн байдал, шалгалтын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл боломжийг хангах, хамтран ажиллах чиглэлээр Өвөрхангай аймаг дахь Политехникийн коллеж, "Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК, Монголын цахилгаан холбоо ХК-ийн Өвөрхангай аймаг дахь Холбооны газарт албан бичиг хүргүүлж, шалгалт авах техник хэрэгсэл, өрөө тасалгааны бэлэн байдлыг хангаж, өрөө тасалгаа, техник хэрэгслийг ариутган халдваргүйжүүлж, шалгалтын бэлтгэл ажлыг хангасан болно.

Төрийн албаны зөвлөлийн Өвөрхангай аймаг дахь салбар зөвлөлөөс 2020 оны 05 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулах төрийн албаны тусгай шалгалт (төрийн захиргааны удирдах, гүйцэтгэх албан тушаал)-ыг зохион байгуулах шалгалтын комиссыг Салбар зөвлөлийн 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 06 дугаар тогтоолоор 5 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, Төрийн албаны зөвлөлийн "Төрийн албаны тусгай шалгалт зохион байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай" 2020 оны 141 дүгээр тогтоол, уг тогтоолыг хэрэгжүүлэх аргачлал, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам"-ыг гишүүдэд хүргүүлж, шалгалтын бүртгэл, зохион байгуулахтай холбоотой асуудлаар танилцуулж, мэдээлэл өгч ажиллалаа.

Шалгалтын комиссын гишүүдийг маск, гар ариутгалын бодисоор хангаж, тусгай шалгалт өгөхөөр ирсэн иргэдийн халууныг хэмжиж, маск, бээлий, улавч өмсгөн шалгалтын танхимд оруулж 2м-ийн зайтай суулгаж, тусгай шалгалт зохион байгуулахтай холбогдуулан гаргасан Төрийн албаны зөвлөлийн шийдвэр, шалгалтын журам, аргачлалыг танилцуулан, төрийн албаны тусгай шалгалтыг 2020 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 10:00 цагт эхэлж тусгай шалгалтыг журам, аргачлалын дагуу товлосон хугацаанд амжилттай зохион байгуулсан.

# ТӨРИЙН АЛБАНЫ ТУСГАЙ ШАЛГАЛТЫН НЭГДСЭН ҮНЭЛГЭЭ

| Д/д | Сонгон шалгаруулалтад оролцогчийн нэр | Шалгалт өгсөн ажлын байрны нэр | Тухайн албан тушаалд хамаарах хууль, эрх зүйн мэдлэгийн үнэлгээ | Дүн шинжилгээ хийх чадварын үнэлгээ | Асуудал шийдвэрлэх чадварын үнэлгээ | Монгол хэлний ярианы болон бичгийн чадварын үнэлгээ | Удирдан зохион байгуулах чадварын үнэлгээ | Манлайлах чадварын үнэлгээ | Багаар ажиллах чадварын үнэлгээ | Үйл ажиллагаа-ны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээ | Нийт оноо | Нийт оноо-гоор эзлэх байр |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 |
| 1 | М.Эрдэнэчулуун | СХАА-ны дарга | 24 | 18 | 12 | 14 | 8.33 | 8.33 | 8.66 | 30 | 123.32 | 1 |
| 2 | Д.Сонинбаяр | Баян-Өндөр сумын ЗДТГ-ын дарга | 18 | 16 | 8 | 14 | 6.66 | 7 | 7.33 | 27 | 103.99 | 1 |
| 3 | Л.Гантулга | Өлзийт сумын ЗДТГ-ын дарга | 20 | 4 | 8 | 14 | 7.33 | 7.33 | 7.66 | 27 | 95.32 | 1 |
| 4 | З.Цэцэгмаа | Хужирт сумын ЗДТГ-ын дарга | 20 | 16 | 12 | 18 | 8 | 8.66 | 8.33 | 30 | 120.99 | 1 |
| 5 | Б.Янжиндулам | Хужирт сумын ЗДТГ-ын дарга | 12 | 10 | 14 | 14 | 7.66 | 8.66 | 8.33 | 27 | 101.65 | 2 |

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ШАЛГАЛТЫН КОМИССЫН ДАРГА Ц.ГАНБОЛД

ТАЙЛАН БИЧСЭН:

ШАЛГАЛТЫН КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Э.БАДАМГЭРЭЛ

# ТӨРИЙН АЛБАНЫ ТУСГАЙ ШАЛГАЛТЫН ЯРИЛЦЛАГЫН ДҮН
## /ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДАХ/

2020.05.18

| № | Шалгалтад оролцогчийн овог, нэр | Удирдан зохион байгуулах чадвар | | | | Манлайлах чадвар | | | | Багаар ажиллах чадвар | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | авбал зохих оноо-10 | | | Онооны дундаж | авбал зохих оноо-10 | | | Онооны дундаж | авбал зохих оноо-10 | | | Онооны дундаж |
| | | 1 гишүүн | 2 гишүүн | 3 гишүүн | | 1 гишүүн | 2 гишүүн | 3 гишүүн | | 1 гишүүн | 2 гишүүн | 3 гишүүн | |
| 1 | М.Эрдэнэчулуун | 9 | 8 | 8 | **8.33** | 9 | 9 | 7 | **8.33** | 9 | 9 | 8 | **8.66** |
| 2 | Д.Сонинбаяр | 7 | 6 | 7 | **6.66** | 7 | 7 | 7 | **7** | 7 | 8 | 7 | **7.33** |
| 3 | Л.Гантулга | 8 | 7 | 7 | **7.33** | 8 | 8 | 6 | **7.33** | 8 | 8 | 7 | **7.66** |
| 4 | З.Цэцэгмаа | 9 | 8 | 7 | **8** | 9 | 9 | 8 | **8.66** | 9 | 8 | 8 | **8.33** |
| 5 | Б.Янжиндулам | 8 | 7 | 8 | **7.66** | 9 | 9 | 8 | **8.66** | 9 | 9 | 7 | **8.33** |

Шалгалтын комиссын гишүүн:................................/Н.Энхцэцэг/

................................/Б.Сайнжаргал/

................................/Э.Бадамгэрэл/

10

# Төрийн албаны тусгай шалгалтад цахимаар бүртгүүлсэн иргэний бичиг баримтыг дэлгэрэнгүй танилцуулга

2020.05.14

| № | Овог, нэр | Регистр | ТАХ-ийн анкет /бүрэн бөглөж, гарын үсэг зурсан байх/ | Оролцогчийн танилцуулга | шалгалтад бүртгүүлэхээр бичгээр гаргасан хүсэлт /гарын үсэг зурсан байх/ | эрүүл мэндийн асуумж хуудас | иргэний үнэмлэхний хуулбар | Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг /диплом/ Хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулга | Нийгмийн даатгалын дэвтэр /Хөдөлмөрийн дэвтэр/-ийн хуулбар | Албан тушаалд томилогдсон, чөлөөлөгдсөн тушаал, шийдвэрийн хуулбар: чөлөөлөгдсөн бол нөөцөд байх үндэслэлийг хангаж байгаа эсэх | Албан тушаалд томилогдсон, чөлөөлөгдсөн тушаал, шийдвэрийн хуулбар: албан тушаалын тодорхойлолтын тургалын шаардлагыг хангасан эсэх, | Албан тушаалд томилогдсон, чөлөөлөгдсөн тушаал, шийдвэрийн хуулбар: Одоогийн албан тушаалд томилогдсон шийдвэр | Төрийн жинхэнэ албаны тангараг өргөсөн "Тангарагийн хуудас" хуулбар | Мэргэшүүлэх сургалтад хамрагдсаныг гэрчлэх баримт бичиг | Хамгийн сүүлийн гурван жилийн төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлсэн илтгэх хуудас, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээ | Сүүлийн 12 сарын хугацаанд сахилгын шийтгэл, ёс зүйн хариуцлага хүлээсэн эсэх талаарх лавлагаа | "4 x 6"-гийн хэмжээний цээж зураг | Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд холбогдох баримт |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Мөнх-Эрдэнэ Эрдэнэчулуун | ЙЮ83052307 | ирсэн | ирсэн | ирсэн | ирсэн | ирсэн | Эдийн засагч-математик загварчлал D200319937 | ирсэн | | ТА-д 8.4 жил ТЗА-д 6.1 жил, ДТ-6.1 жил, мэргэшсэн нягтлан бодогч | Санхүүгийн хяналт шалгалтын ахлах байцаагч, аудитороор томилсон 2017.01.12 Б/01 дүгээр тушаал | 2016.02.08 | * | 2017 он-94%, 2018 он-92% 2019 он-90% | 2020.05.13-ны 1/160 тоот албан бичиг | ирсэн | |
| 2 | Зоригт Цэцэгмаа | йс72011508 | бүрэн бөглөсөн | ирсэн | ирсэн | ирсэн | ирсэн | Төрийн захиргааны менежмент D200721671 | ирсэн | | ТА-д 18.7 жил ТЗА-д 15 жил, ДТ-12.5 жил, ТТ-2.7 жил | БОХУБ-аар 2004.04.26-ны 53 дугаар тушаал | 2006.11.26 | * | 2017 он-96.8%, 2018 он-96.8% 2019 он-96.8% | ирсэн | ирсэн | |
| 3 | Цэрэндорж Галбадрах | ЙС82100737 | дутуу бөглөсөн | ирсэн | дутуу бөглөсөн | ирсэн | ирсэн | Банкны эдийн засаг, мэдээлэл зүй D200402753 | ,НДД ирүүлээгүй. НДШ төлөлтийн тодор ирсэн | | ТА-д 10.10 жил ТЗА-д 10.10 жил, ДТ-9.2 жил, ТТ-1.7 жил | ирүүлээгүй | 2009.08.25 | | ирүүлээгүй | ирсэн | ирсэн | |

| | | | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | Дашням Мөнхбат | ЙС82072556 | ирсэн | ирсэн | ирсэн | ирсэн | ирсэн | Газар зохион байгуулагч-инженер D200502611 | бүртгэлийн зааврын дагуу ирүүлээгүй | ГХБХБГ-ын 2018.11.27-ны б/18 тушаал | мэргэжил тохирохгүй, ДТ-ийн албан тушаалд ажиллаагүй. ТА-д 13.2 жил ТЗ-д13.2 жил ТТ-11.9 жил, түр орлон-1.5 жил | Хужирт сумын ЗДТГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр 2018.11.28-ны Б/06 захирамж | 2008.07.10 | | хэдэн он нь мэдэгдэхгүй баталгаажуулж гарын үсэг зурсан зүйлгүй 95.5 үнэлгээтэй | ирсэн | ирээгүй | |
| 5 | Буянтогтох Янжиндулам | ЙС75051309 | ирсэн | ирсэн | ирсэн | ирсэн | ирсэн | Байгаль хамгаалал экологич, D200926481 | ирсэн | | ТА-д 15.4 жил ТЗА-15.4 жил ДТ-д 12.4 жил ТТ-д 2.2 жил | аймгийн МХГ-ын даргын 2005.01.20-ны 02 тушаал | 2006.11.26 | | 2017 он-88.7% 2018 он-92.1% 2019 он-92.1% | ирсэн | ирсэн | |
| 6 | Далай Сонинбаяр | йг84041719 | Заавраын дагуу ирүүлээгүй ирсэн | ирсэн | ирсэн | ирсэн | ирсэн | Ус судлал D200713032 | ирсэн | 2011.12.14-ний 19 дүгээр тушаал бүтэц орон тоо өөрчлөг деж | ТА-д 10.8 жил ТЗА-10.8 жил ДТ-8.4 жил ТТ-2.3 жил | 2009.07.18-ны 13 тушаал, УБЕГ-ын Баян-Өндөр сумын улсын бүртгэгч 2011.12.26-ны 999 тушаал | 2010.01.13 | | 2017 он-87.5% 2018 он-90.5% 2019 он-90.5% | ирсэн | ирсэн | |
| 7 | Пүрэвдагва Баатар | ЕП63121414 | ирсэн | ирсэн | ирсэн | ирсэн | ирсэн | ЦНДС-ийг улс төрийн ажилтан №02222 /2011 онд гал түймэр гарч шатсан ОБЕГ-ын акттай диплом нөхөж аваагүй/. Мэргэжил тохирохгүй | ирсэн | 2016.11.23-ны б/40 сумын Засаг даргаас чөлөөлсөн. Төрийн жинхэнэ албаны нөөцөд байхгүй | ТА-д 25.10 жил, ТЗА-д 8 жил, ТТ-4 жил, ДТ-4 жил | ирсэн | ирээгүй | | ирүүлээгүй | ирүүлээгүй | ирээгүй | |
| 8 | Лүвээнжав Гантулга | ЙК69020511 | ирсэн | ирсэн | ирсэн | ирсэн | ирсэн | ХААҮС-ийг мал зүйч №121526 | ирсэн | | ТА-д 23.11 жил ТЗА-19.5 жил ДТ-д 4.4 жил ТТ-15.1 жил | 2009.08.03-ны 16 дугаар тушаалаар ЗДТГ-ын мэргэжилтнээр томилсон | 2002.9.23 | | 2017 он-93.2% 2018 он-88.0% 2019 94.5% | ирсэн | ирсэн | |